



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

f [facebook.com/Rtcc.m0n](https://www.facebook.com/Rtcc.m0n)
🌐 <http://rtcc.mrtd.gov.mn>
✉ info@rtcc.mrtd.gov.mn
☎ +976 77244409

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН
2019 оны арваннэгдүгээр сарын дугаар



Дорнод, Сүхбаатар аймгуудад баригдах төмөр замын бүтээн байгуулалтын судалгааны ажлуудтай танилцах хуралд оролцлоо.

Шинээр баригдах Сайншанд-Тамсагбулаг чиглэлийн 610 км төмөр замын дагуу судалгаа хийх, шинэ төмөр замын шугамын ерөнхий байдалтай танилцах зорилгоор “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын Захирал А.Буяннэмэх, төвийн мэргэжилтнүүдийн хамтаар 2019 оны 11 дүгээр сарын 6-10- ны өдрүүдэд Баруун-Урт хотод ажилласан.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Зам Тээврийн Хөгжлийн сайд Б.Энх-Амгалан болон салбарын мэргэжилтнүүдийн хамарсан хуралд ГТХЗНТ УТҮГ-ын нэвтрүүлэх технологи, хийгдэхээр төлөвлөсөн ажлын талаар танилцуулга хийлээ.



Энэхүү хуралд ЗТХЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлого хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Артур “Зүүн бүсийн төмөр замын танилцуулга”, Хүнд үйлдвэр, газрын тосны бодлого хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Анхбаяр “Үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийг эрчимжүүлэх”,

Монголын Логистик Холбооноос “Монголын газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай түүхий тосыг нийлүүлэх дэд бүтцийн харьцуулсан судалгаа”-ны талаарх илтгэлийг тус тус танилцуулав.



Хурлын төгсгөлд Монгол Улсын Ерөнхий Сайд У.Хүрэлсүх Засгийн газраас төмөр замын талаар баримталж буй бодлогын хэрэгжилтэд анхаарч ажиллах үүрэг өглөө.

Дотоод судалгаа



Дорнод, Сүхбаатар аймгуудад баригдах өртөөний зам баригдах газрын нөхцөл байдалтай танилцаж санал солилцлоо.

2019 оны 11-р сарын 8-ны өдөр Баруун-Урт хотод баригдах өртөөний байршилтай танилцан, орон нутгийн холбогдох албаны хүмүүстэй уулзлаа.



2019 оны 11-р сарын 9-ны өдөр Дорнод аймгийн Тамсагбулаг сумын нутагт баригдах өртөөний газрын байршил, нөхцөл байдалтай танилцаж санал солилцов.



ОХУ-ын “Эрхүүгийн зам харилцааны улсын их сургууль” -ийн төлөөлөгчидтэй төмөр замын инженер, техникийн ажилтныг мэргэшүүлэх сургалт зохион байгуулах талаар санал солилцлоо.

Эрхүүгийн зам харилцааны улсын их сургуулийн нэгдүгээр орлогч дарга А.И.Орленка, олон улсын боловсролын хөтөлбөрийн төвийн дарга Ю.А.Маланина, гадаад оюутан хариуцсан декан В.М.Манжеева нар хүрэлцэн ирж Төвийн захирал А.Буяннэмэхтэй уулзаж санал солилцов.



Энэхүү уулзалт нь төмөр замын инженер, техникийн ажилтныг өндөр технологи бүхий олон улсад үе шаттайгаар сургаж, чадварыг дээшлүүлэн мэргэшүүлэх зорилтын хүрээнд “мэдээлэл технологийн инженер” мэргэжлээр 2,5 жилээр эчнээ сургалт зохион байгуулах талаар хэлэлцэж хамтран ажиллахаар боллоо.



"Залуу инженерүүдийн үндэсний чуулган - 2019" боллоо.

Засгийн газрын бүтээн байгуулалтын ажлыг залуучуудад танилцуулах, залуу инженерүүдийн хөгжлийн төлөөх үзэл бодол, санал санаачилгыг төрд хүргэх зорилгоор "Нийгмийн Ардчилал Монголын Залуучуудын Холбоо"-ноос санаачлан Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор "Залуу инженерүүдийн үндэсний чуулган-2019" амжилттай зохион байгуулагдлаа.

"Залуу инженерүүдийн үндэсний чуулган"-д таван салбарын 1000 гаруй залуус чуулж, Аж үйлдвэрийн IV хувьсгал, шинэ санаачилга, инноваци, мэргэжлийн залуу үеийг дэмжих гэсэн гол сэдвүүдийг хөндөн хэлэлцлээ.

Байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаанд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа шинэ технологийн хөгжлийн талаар санал бодлоо солилцсон юм.



Салбар хэлэлцүүлгийг нээж Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд “Аливаа улс орны хөгжлийг олон зүйлээр тодорхойлох боловч дэд бүтцийн салбар нь улс орнуудын хөгжлийн үндсэн суурь нь болж өгдөг ба энэ утгаараа дэлхийн өрсөлдөх чадварын тайланд улс орнуудын өрсөлдөх чадварыг 4 үндсэн хэсгээр хэмждэгийн нэг нь дэд бүтэц юм. Дэд бүтэц, ялангуяа зам тээврийн сүлжээний нягтрал, хүртээмж сайн байх нь тухайн улсын эдийн засгийн бүхий л салбарын хөгжлийн гол түлхэх хүч болдог. Олборлосон ашигт малтмал, хураан авсан ургац, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, технологи зэргийг нь зах зээлд хүргэн эргэлтэд оруулснаар үнэ цэнд хүрдэг бөгөөд зах зээлд хүргэх үүрэг нь тээврийн салбарт ногддог. Тухайн бүтээгдэхүүний өөрийн өртөг дээр тээвэрлэлтийн үнэ нэмэгдсэнээр зах зээлийн үнэ, түүнээс олох ашиг тодорхойлогддог тул тээврийн салбар нь өргөн утгаараа бусад салбарын хөгжлийн нэгэн тулгуур багана юм” хэмээв.

Тиймээс ч зам тээврийн салбарт эдийн засгийн өсөлтийг хангах, эрэлтэд нийцсэн, тогтвортой, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай, байгаль орчинд ээлтэй, бүс нутагт өрсөлдөхүйц тээврийн үйлчилгээ үзүүлэгч салбар болох зорилт тавин ажиллаж байгаа гэдгийг онцолж байв.

Хамтын ажиллагаа



Салбар бүр өөрийн онцлог улс орны хөгжилд оролцох оролцоог тодорхойлж дэлхийн хөгжил хаана явна, манай салбар энэ хөгжлийн хаана нь байна вэ, дэлхийн технологийн хөгжлийг гүйцэхэд мэдлэгийн бөгөөд хүний нөөц бэлэн үү, бидэнд ямар тулгамдсан асуудал байна зэрэг асуултанд хариулт эрэлхийлж хэлэлцүүлгээ зохион байгууллаа.



Энэхүү хэлэлцүүлгийн хүрээнд Монгол Улсын зам, тээврийн салбарт авто замын тээвэр, агаарын тээвэр, төмөр замын тээвэр, далай ашиглалт, усан замын тээвэр гэсэн тээврийн төрлүүд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд цаашид тээврийн шинэ төрлүүдийг хөгжүүлэх зайлшгүй эрэлт хэрэгцээ үүсч байгаа гэдэгтэй зам, тээврийн салбарын залуучууд санал нэгдэж, залуусын санаачилгаар “Залуу инженерүүдийн үндэсний сүлжээ”-г байгуулж, Үндэсний чуулганаас гарсан санал, санаачилгыг Монгол улсын засгийн газарт уламжиллаа.

Нийт залуу инженерүүд, оролцогч та бүхэндээ талархсанаа илэрхийлье.

Залуу инженерүүдийн оролцоо ирээдүйг бүтээнэ.



“Хог биш баялаг” сэдэвт сургалтад төвийн мэргэжилтнүүд хамрагдлаа.

Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 98 дугаар тогтоолоор батлагдсан “Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”, Ногоон хөгжлийн бодлого эдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу байгууллагын үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, ялгах, ангилах, дахин боловсруулах, хадгалах, тээвэрлэх ажлыг байгаль орчинд ээлтэй дэвшилтэд байдлаар шийдэх, ажилтнуудыг хогоо хэрхэн ангилах талаар 2019.11.21-ний өдөр “Хоггүй Монгол” ТББ-аас “Хог биш баялаг” сэдэвт сургалт зохион байгуулагдлаа.



ХАБЭА -н мэргэжилтнүүдийн хэлэлцүүлэгт оролцлоо.

Зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооноос 2019 онд баталсан төлөвлөгөөний дагуу яамны харьяа байгууллага, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоод, Үйлдвэрчний эвлэл зэрэг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан тушаалтнуудын дунд туршлага солилцох, мэдлэг хуваалцах арга хэмжээнд 11 дүгээр сарын 15-ны өдөр оролцож хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлж тус чиглэлээр 2019 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг танилцууллаа.



Зам, тээврийн салбарт дээрх чиглэлээр хэрэгжиж байгаа арга хэмжээний үр дүн, түүний явцыг харахад сайн туршлагыг нэвтрүүлэх, мэдлэг мэдээллээ нээлттэй, чөлөөтэй солилцох, тулгамдаж байгаа асуудлаа хэрхэн шийдвэрлэх талаар ярилцаж, алдаа, дутагдалдаа дүн шинжилгээ хийх, 2020 онд хийх арга хэмжээгээ төлөвлөх зэрэг хийх ажлуудыг зохион байгуулахаар боллоо.

Төвийн үйл ажиллагаа



Мэргэжилтнүүдийн ажлын үр дүнг үнэлэх загвар, Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэмэлтээр тусгах саналын товъёо боловсруулаа.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 348 дугаар тушаалаар баталсан ажлын хэсгийн хүрээнд Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах санал болон Засгийн газрын хэрэг эрхлэх газраас Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах саналын товъёо боловсруулж ЗТХЯ-нд хүргэж танилцуулав.

“ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2019.11.06-ны өдрийн А/68 дугаар тушаалаар баталсан ажлын хэсгийн хүрээнд ГТХЗНТ-д хуулиар тусгайлан олгосон болон нийтлэг чиг үүргийн судалгаа боловсруулав. ГТХЗНТ-ийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад гарын авлага болгон ашиглах зорилгоор хийгдсэн судалгаанд 42 хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг хамруулж 737 чиг үүргийн жагсаалт гарсан болно.

Төвийн үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг сайжруулах, ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг урамшуулал, хариуцлагатай холбож ажиллах зорилгоор хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулж, ажилтнуудын ажлын үр дүнгийн үнэлгээний хуудас, ажлын үр дүнг үнэлэх үлгэрчилсэн загварыг “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2019 оны А/67 дугаар тушаалаар батлуулав.



ГТХЗНТ-ийн 2019 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний биелэлт болон нэмэлт ажлын мэдээллийг боловсруулав.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Цалин хөлсний талаар үндэсний хэмжээнд баримтлах бодлого”-ыг танилцуулах зорилгоор Ажил олгогч, ажилтны ҮЭХ-ны хамтарсан уулзалт зохион байгуулав. Уулзалтаас цалин хөлсний зөвлөл байгуулах, хамтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг харилцан тохиролцов.

Ган зам сонины 2019.11.05-ны өдрийн №45 (4393) дугаарт “Монгол баатарлаг туульсаа дээдлэн дэлгэрүүлэх нь” сэдвээр мэдээлэл нийтлүүлж, “Монгол Жангар туулийг номын сангуудад бэлэглэжээ” сэдэвт мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт байршуулж сурталчилж ажилласан.





1. Шинжуку - Япон улс, Токио

Шинжуку буудал бол өдөр бүр 3.5 сая орчим зорчигчид үйлчилдэг дэлхийн хамгийн их ачаалалтай галт тэрэгний буудал бөгөөд JR-East, Одакю Цахилгаан төмөр зам, Кэйо корпораци, Токио метро болон Тоей метро гэсэн таван өртөөнөөс бүрддэг.

Энэ буудал нь Токио хотын төв ба баруун хэсгийг хооронд холбодог нийт 20 зам, 12 чиглэлийн галт тэрэгний шугамд үйлчилдэг нийт 10 зорчигчийн тавцан байдаг.

Тус өртөө нь 1885 онд анх нээгдэж байсан ба 1915, 1923 онд Кэйо, Одакюгийн шугамууд нээгдсэнээр тус өртөөгөөр дамжин өнгөрөх




2. Хаутбахноф - Швейцар, Цюрих



Өдөр бүр нийт 2900 галт тэрэг энэ өртөөгөөр дайран өнгөрдөг бөгөөд энэ нь Европ дахь хамгийн ачаалалтай буудлуудын нэг болжээ.

Энэ галт тэрэгний буудал нь олон тооны маршрутуудыг туршиж үзсэн бөгөөд хэсэг хэсгээр нь нэмж, S-Bahn галт тэрэгний шугам болон бусад бүтэцүүдээр дамжуулан төмөр замын буудалд цугларч буй зорчигчдын урсгалыг зөв менежментийг бий болгож чадсан юм.

3. Гейр дү Норд - Франц улс, Парис



Жил бүр ойролцоогоор 180 сая аялагч дамжин өнгөрдөг тул дэлхийн хамгийн ачаалалтай өртөөдийн нэг болжээ. Одоо галт тэрэгний буудал нийт 44 зорчигчийн тавцантайгаар ажиллаж байна. Энэ өртөө нь 1964 онд томоохон өргөтгөл хийж, хүчин чадлаа нэмэгдүүлсэн байна.



**Газар бизнес төвийн байр,
Тээвэрчдийн гудамж,
2-р хороолол, 1-р хороо,
Баянгол дүүрэг, 16052,
Улаанбаатар хот, Монгол улс**

